



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн 1 дүгээр сургууль 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2023/12-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn Дархан сум 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089, 99023682 Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: ЦЭСБ-Аудит ХХК Утас: 95112689 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45056
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.25 № 112

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дархан сумын 1 дүгээр сургуулийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 81.6 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх НДШ, 2.9 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал тус тус эзэлж байна.

Аудитын гол асуудал

Дархан сумын 1 дүгээр сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/343 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр үнэлэгдээгүй, урамшуулал санхүүжилт аваагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

000020154

Дархан сумын 1 дүгээр сургууль нь байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 8 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 94.5 хувиар биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	82,592,925.61	175,615,764.63
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	-	83,125,113.42
311	Кассанд байгаа	-	
312	Банкинд байгаа		83,125,113.42
33	АВЛАГА	364,000.00	-
	Хувь хүнээс авах	364,000.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	82,228,925.61	92,490,651.21
351	Түүхий эд материал	39,702,006.96	638,988.00
35110	Тусгай зориулалттай материал	38,782,458.96	
35130	Эм боох материал	919,548.00	638,988.00
354	Хангамжийн материал	42,526,918.65	91,851,663.21
35410	Бичиг хэргийн материал	448,000.00	3,893,650.00
35420	Аж ахуйн материал	21,126,373.65	21,126,373.65
35470	Бусад хангамжийн материал	20,952,545.00	66,831,639.56
356	Мал амьтад		
36	НӨӨЦИЙН БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,272,980,646.85	3,376,326,360.11
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,272,980,646.85	3,376,326,360.11
392	Биет хөрөнгийн дүн	2,736,139,330.16	2,836,313,903.42
39201	Барилга байгууламж	2,778,287,000.00	2,836,970,320.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(276,820,588.68)	(361,570,241.70)
39205	Машин тоног төхөөрөмж	256,286,993.54	283,274,362.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	(162,903,292.13)	(169,061,993.90)
39207	Тавилга, эд хогшил	161,587,664.56	212,508,361.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(117,817,713.04)	(52,220,845.98)
39212	Бусад үндсэн рөнгө	76,116,600.00	76,116,600.00
39213	Хуримтлагдсан элэгдэл	(25,380,003.92)	(35,822,888.84)
39217	Ном	46,782,669.83	46,120,230.30
393	Биет бус хөрөнгийн дүн	536,841,316.69	540,012,456.69
39301	Программ хангамж	2,324,300.00	2,324,300.00
39302	Хасагдуулга	(562,149.90)	(1,987,009.86)
39303	Бусад биет бус хөрөнгө	535,750,000.00	540,696,000.00
39304	Хасагдуулга	(670,833.41)	(1,020,833.45)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,355,573,572.46	3,551,942,124.74
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,355,573,572.46	3,551,942,124.74
51	Засгийн газрын хувь оролцоо	1,565,471,243.90	3,355,573,572.46
51101	Өмч: -төрийн	1,565,471,243.90	
51102	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		3,355,573,572.46
512	Хуримтлагдсан үр дүн	1,790,102,328.56	196,368,552.28
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,309,533,330.77)	
51220	Тайлант үеийн үр дүн	3,099,635,659.33	196,368,552.28
6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН	3,355,573,572.46	3,551,942,124.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,174,489,568.12	1,793,223,898.65
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,535,713.12	259,105,812.80
120	Нийтлэг татварын бус орлого	19,535,713.12	259,105,812.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,171,239.08	6,053,598.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,622,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	980,925.00	2,431,598.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	190,314.08	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	5,361,511.08	248,156,529.20
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	13,002,962.96	4,895,685.60
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,099,222,700.00	93,978,485.85
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,099,222,700.00	
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,154,953,855.00	1,534,118,085.85
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	1,440,139,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,440,139,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүдгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,210,084.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	8,205,984.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,100.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,521,071.00	93,978,485.85
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,521,071.00	93,978,485.85
2	Үйл ажиллагааны зардал	1,257,158,011.86	1,550,398,117.20
21	Урсгал зардал	1,257,158,011.86	1,550,398,117.20
210	Бараа, үйлчилгээний зардал	1,210,624,282.92	1,434,486,510.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	922,058,508.34	1,056,208,658.30
210101	Үндсэн цалин	544,574,308.34	720,547,033.35
210102	Нэмэгдэл цалин	323,464,512.00	258,975,612.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,489,772.00	1,487,191.00
210104	Урамшуулал	52,529,916.00	50,225,321.95
210106	Гэрээт ажлын хөлс		24,973,500.00
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	119,789,900.00	133,906,732.13
210201	Тэтгэврийн даатгалын	83,077,400.00	92,013,787.51
210202	тэтгэмжийн даатгалын	9,214,600.00	10,783,828.66
210203	ҮОМШӨ-ий даатгалын	7,015,800.00	8,522,862.35
210204	Ажилгүйдлийн даатгалын	1,832,900.00	2,044,221.65
210205	ЭМ-ийн даатгалын	18,649,200.00	20,542,031.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,489,321.59	42,964,623.23
210301	Гэрэл цахилгааны зардал	2,941,960.84	5,515,044.67

210302	Түлш, халаалтын зардал	26,858,687.67	29,972,032.00
210303	Цэвэр бохир усны зардал	2,688,673.08	7,477,546.56
2104	Хангамж, бараа материалын зардал	8,356,873.13	1,006,300.00
210401	Бичиг хэргийн зардал	1,648,232.00	51,000.00
210404	Тээвэр шатахуун	300,000.00	40,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн зардал	1,558,231.13	
210404	Ном, хэвлэл	326,000.00	
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	870,350.00	
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал	3,654,060.00	915,300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	955,150.00	86,910.00
210502	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	655,150.00	86,910.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,185,687.60	3,339,270.00
210601	Тавилга	12,687.60	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		
210604	Урсгал засварын зардал	12,173,000.00	3,339,270.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	1,503,000.00	10,206,720.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр		3,622,000.00
210802	Аудит баталгаажуулалтын зардал	660,000.00	
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	843,000.00	6,584,720.00
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	113,285,842.26	186,767,297.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	141,460.00	29,632,660.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	2,495,000.00	8,764,783.32
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	110,649,382.26	148,369,853.89
213	Урсгал шилжүүлэг	46,533,728.94	115,911,606.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,341,100.00	113,609,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	45,341,100.00	113,609,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,160,879.53	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,160,879.53	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,749.41	2,302,606.33
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,749.41	2,302,606.33
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		
3	Үйл ажиллагааны үр дүн	(82,668,443.74)	242,825,781.45
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	43,864,160.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	43,864,160.00	(46,457,228.73)
4	Үйл ажиллагааны бус үр дүн	(43,864,160.00)	(46,457,228.73)
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	(126,532,603.74)	196,368,552.72

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,155,934,780.00	1,540,171,683.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	980,925.00	6,053,598.00
120	Нийтлэг татварын бус орлого	980,925.00	6,053,598.00
120002	Хүүгийн орлого		
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	980,925.00	6,053,598.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,622,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	980,925.00	2,431,598.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,099,222,700.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,099,222,700.00	
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	55,731,155.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	1,440,139,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,440,139,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,210,084.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	8,205,984.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,100.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,521,071.00	93,978,485.85
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,521,071.00	93,978,485.85
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,152,399,780.00	1,407,006,970.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,152,399,780.00	1,407,006,970.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,105,866,051.06	1,291,095,364.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	922,058,508.34	1,056,208,658.30
210101	Үндсэн цалин	544,574,308.34	720,645,897.35
210102	Нэмэгдэл	323,464,512.00	258,975,612.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,489,772.00	1,487,191.00
210104	Урамшуулал	52,529,916.00	50,126,457.95
210106	Гэрээт ажлын хөлс		24,973,500.00
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,789,900.00	133,906,732.13
210201	Тэтгэврийн даатгалын	83,077,400.00	92,013,787.51
210202	Тэтгэмжийн даатгалын	9,214,600.00	10,783,828.66
210203	ҮОМШӨ-ий даатгалын	7,015,800.00	8,522,862.35
210204	Ажилгүйдлийн даатгалын	1,832,900.00	2,044,221.65
210205	Эрүүл мэндийн даатгалын	18,649,200.00	20,542,031.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,489,321.59	42,964,623.67
210301	Гэрэл цахилгааны зардал	2,941,960.84	5,515,044.67
210302	Түлш, халаалтын зардал	26,858,687.67	29,972,032.44
210303	Цэвэр бохир усны зардал	2,688,673.08	7,477,546.56
2104	Хангамж, бараа материал	7,081,083.13	-
210401	Бичиг хэргийн зардал	981,152.00	
210404	Тээвэр шатахуун	300,000.00	
210403	Шуудан холбооны зардал, мэдээлэл тех-гийн үйлчилгээ	1,558,231.13	

210404	Ном	419,000.00	
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	1,129,318.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,693,382.00	
2105	Нормативт зардал	1,735,730.00	-
210501	Эм	505,730.00	
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас	1,230,000.00	
2106	Эд хогшил урсгал засвар	15,000,000.00	6,653,370.00
210601	Багаж техник хэрэгсэл		109,900.00
210604	Урсгал засвар	15,000,000.00	6,543,470.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоодын томилолт		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	1,503,000.00	10,162,720.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,622,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	660,000.00	
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	843,000.00	6,540,720.00
210807	Газрын төлбөр		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,208,508.00	41,199,260.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	141,460.00	27,814,980.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	6,067,048.00	13,384,280.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,533,728.94	115,911,606.33
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,341,100.00	113,609,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	45,341,100.00	113,609,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,160,879.53	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,160,879.53	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэлт	31,749.41	2,302,606.33
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,749.41	2,302,606.33
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	3,535,000.00	133,164,713.42
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	3,535,000.00	(50,039,600.00)
222001	Тоног төхөөрөмж		(39,389,600.00)
223001	Бусад хөрөнгө	3,535,000.00	(10,650,000.00)
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(3,535,000.00)	(50,039,600.00)
7	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(0.00)	83,125,113.42
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		83,125,113.42

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	1,565,471,243.90	3,099,635,659.33	(1,142,676,867.48)	3,522,430,035.75
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(162,972,463.29)	(162,972,463.29)
2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	1,565,471,243.90	3,099,635,659.33	(1,309,533,330.77)	3,355,573,572.46
НББ-ийн бодлогын өөрчлөлт			1,309,533,330.77	1,309,533,330.77
ҮХ-ийн өсөлт, бууралт	1,790,102,328.56	-		1,790,102,328.56
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт		(3,099,635,659.33)		(3,099,635,659.33)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			196,368,552.28	196,368,552.28
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	3,355,573,572.46	-	196,368,552.28	3,551,942,124.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,546,225,285.85	1,454,743,964.10	(91,481,321.75)	94.1
21	Урсгал зардлын дүн	1,546,225,285.85	1,404,704,364.10	(141,520,921.75)	90.8
210	Бараа үйлчилгээний зардал	1,422,720,185.85	1,291,095,364.10	(131,624,821.75)	90.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,107,821,585.95	1,056,208,658.30	(51,612,927.65)	95.3
210101	Үндсэн цалин	806,136,368.00	720,645,897.35	(85,490,470.65)	89.4
210102	Нэмэгдэл	257,108,620.00	258,975,612.00	1,866,992.00	100.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт		1,487,191.00	1,487,191.00	
210104	Урамшуулал	19,603,097.95	50,126,457.95	30,523,360.00	255.7
210105	Гэрээт ажлын хөлс	24,973,500.00	24,973,500.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,477,599.90	133,906,732.13	(4,570,867.77)	96.7
210201	Тэтгэврийн даатгал	94,164,900.00	92,013,787.51	(2,151,112.49)	97.7
210202	Тэтгэмжийн даатгал	11,078,200.00	10,783,828.66	(294,371.34)	97.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,862,499.90	8,522,862.35	(339,637.55)	96.2
210204	Ажилгүйдлийн даатгал	2,215,600.00	2,044,221.65	(171,378.35)	92.3
210205	ЭМД-ын хураамж	22,156,400.00	20,542,031.96	(1,614,368.04)	92.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,264,700.00	42,964,623.67	(2,300,076.33)	94.9
210301	Гэрэл цахилгааны зардал	5,754,700.00	5,515,044.67	(239,655.33)	95.8
210302	Түлш, халаалтын зардал	28,200,000.00	29,972,032.44	1,772,032.44	106.3
210303	Цэвэр бохир усны зардал	11,310,000.00	7,477,546.56	(3,832,453.44)	66.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,431,600.00	6,653,370.00	(5,778,230.00)	53.5
210601	Багаж хэрэгсэл	2,431,600.00	109,900.00	(2,321,700.00)	4.5
210604	Урсгал засвар	10,000,000.00	6,543,470.00	(3,456,530.00)	65.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	15,335,500.00	10,162,720.00	(5,172,780.00)	66.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	3,622,000.00	3,622,000.00	-	100.0
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	11,713,500.00	6,540,720.00	(5,172,780.00)	55.8
210807	Газрын төлбөр			-	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,389,200.00	41,199,260.00	(62,189,940.00)	39.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	85,818,900.00	27,814,980.00	(58,003,920.00)	32.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,570,300.00	13,384,280.00	(4,186,020.00)	76.2

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	123,505,100.00	113,609,000.00	(9,896,100.00)	92.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	123,505,100.00	113,609,000.00	(9,896,100.00)	92.0
213205	Төсвөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	123,505,100.00	113,609,000.00	(9,896,100.00)	92.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	50,039,600.00	50,039,600.00	
	Дотоод эх үүсвэрээр			-	
	Тоног төхөөрөмж		39,389,600.00	39,389,600.00	
	Бусад хөрөнгө		10,650,000.00	10,650,000.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,546,225,285.85	1,537,869,077.52	(8,356,208.33)	99.5
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,446,193,200.00	1,440,139,600.00	(6,053,600.00)	99.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,446,193,200.00	1,440,139,600.00	(6,053,600.00)	99.6
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	93,978,485.85	91,675,879.52	(2,302,606.33)	97.5
132001	Орон нутгийн төсвөөс	93,978,485.85	91,675,879.52	(2,302,606.33)	97.5
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,053,600.00	6,053,598.00	(2.00)	100.0
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,622,000.00	3,622,000.00	-	100.0
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,431,600.00	2,431,598.00	(2.00)	100.0
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		83,125,113.42	83,125,113.42	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 32,295.0 мянган төгрөгийн алдаа илэрч аудитын явцад залруулав.

1. Урьдчилгаа цалин 27,300.0 мянган төгрөгийг шууд зардалд бүртгэсэнийг залруулав.

2. Үндсэн хөрөнгийн чанартай 4,995.0 мянган төгрөгийг бараа материал дансанд бүртгэсэнийг залруулав.

Аудитаар 1,400.0 мянган төгрөгийн зөрчил илэрч 1,400.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөв.

Зөвлөмж

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

1.1 Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь “*Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна*”, 8.1.5 дахь “*санхүүгийн тайлангийн тодруулга*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг хийж байх.

2. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

2.1 Илрүүлэлт: Тайлант онд 1,400.0 мянган төгрөгийн бичиг худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ*” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

